Баян-Олгий аймгийн Олгий суманд vйлчилгээ сайтай нэг л орхийн эмнэлэг байгаа гэж хэлж болно. Зургаа, ес, аравдугаар багийн дунд оршдог «Шипагер» орхийн эмнэлэг 8250 хvнд эрvvл мэндийн тусламж vзvvлдэг.

Тэдний 1000 гаруй нь хэдэн жилийн омноос эдгээр багт оршин суудаг мортлоо тус сумын иргэнээр бvртгvvлээгvй тvр оршин суугчид юм. Харин эмнэлгийн тусламж хэрэгтэй болоход эмч нар оргосон тангарагийнхаа дагуу аргагvйн эрхэнд тэдэнд vйлчилдэг ч дорвон их эмч, таван сувилагч, гурван ажилчинтай энэ эмнэлэг ачаалал ихтэй, илvv цагаар ажилладаг байна. Эдгээр багт ядуу орх айл олон, онгорсон онд гэхэд жирэмсэн 246 эхийг хяналтандаа авч тусалжж vйлчилсээр байгаад хонгорvvлж, эх нялхсын эндэгдэл гаргаагvй, нэгдсэн эмнэлгийн торох тасгийн эмч нартай хамтран эхчvvдэд vзлэг хийж, эрvvл мэндийн эрсдэлтэй зургаан эхийг жирэмслэхээс татгалзуулсан байна. Жирэмсэн эх, нярайчуудад тогтоосон журмын дагуу тогтмол vйлчилдэг.

Халдварт овчний тархалт буурсан ч урьдчилан сэргийлэх вакцин хийхээр дуудаж, урилга огоод ч хvмvvс хамрагддаггvй нэг гэм байна гэж эмч нар нь ярьж байна. Гэтэл vvнээс бусад орхийн эмнэлгvvд vvргээ сайн биелvvлдэг нь ховор, тэд зориулалтынхаа дагуу орхvvдээр явж vйлчлилбэл зохино гэж хvмvvс ярьдаг. Энэ эмнэлэг тохилог байртай болсон, удахгvй бас  тус суманд орхийн хоёр эмнэлэг шинэ байртай болох юм байна.

**Баян- Өлгий аймаг Ш. Айбек**